



ШИНЭ ҮЕ СУРГУУЛЬ ХЭЛНИЙ ТУХАЙ ЖУРАМ

Боловсруулсан: 2018 оны 2 сар

Шинэчилсэн: 2019 оны 6 сар

Шинэчлэн найруулсан: 2021 оны 6

Дахин хянах: 2023 оны 6 сар

Хэрэгжих хүчинтэй хугацаа: 2021-2023 он

Шинэ Үе сургууль

2021

“Олон улсын баклавриат” гэдэг нэршлийг цаашид АйБи гэж товчилж буй. Энэ нь баклавын зэрэг биш хэдий ч баклавын суурь болох их сургуулийн бэлтгэл хөтөлбөр юм.

АйБи хөтөлбөрийн эрхэм зорилго

АйБи хөтөлбөр нь мэдлэг чадвартай, сонирхон судалдаг, хүн төрөлхтний өв уламжлал, ёс заншил, хэл соёлыг хүндлэн дээдэлж эх дэлхийн энх тайвныг эрхэмлэдэг, илүү сайхан ертөнцийг бүтээж чадах шинэ залуу үеийг бэлдэхийг эрхэм зорилгоо болгодог. Бид олон улсын байгууллага, засгийн газруудтай хамтран ажиллаж, олон улсын жишигт нийцсэн боловсролын хөтөлбөр боловсруулж, шударга, нягт шалгах үнэлгээний аргачлалыг улам бүр хөгжүүлсээр байна. Энэхүү хөтөлбөрөөр суралцаж буй хүүхэд бүр идэвхтэй, хүсэл тэмүүлэлтэй, хүн бүрийн онцлог зан чанарыг ойлгон хүндэтгэж чаддаг, насан туршдаа сурч боловсрох чадвартай иргэн болон төлөвшдөг.

Шинэ Үе сургуулийн эрхэм зорилго

Бид шинэ үеийнхнийг

Халамжтай

Хариуцлагатай

Хүнлэг

Хичээнгүй

Эрүүл чийрэг

Эрдэм боловсролтой

Эх хэл, өв уламжлалаа хайрлан хамгаалдаг

Энэ дэлхийн улс, үндэстэн бүрийн ёс заншил, ахуй соёлыг хүндлэн дээдлэх иргэн болгож төлөвшүүлнэ.

АйБи хөтөлбөрийн зохицуулагч

Нэр: Т.Ханджав

Утас: +976 9111 7811

Имэйл: khandjav@shineue.edu.mn

Хаяг: СБД, 1-р хороо, Юнескогийн гудамж 12, Шинэ Үе сургууль, АйБи Оффис

АйБи хөтөлбөрийн зохицуулагчийн туслах

Нэр: Б.Молор-Эрдэнэ

Утас: +976 8870 0938

Имэйл: boldbaatar.m@shineue.edu.mn

Хаяг: СБД, 1-р хороо, Юнескогийн гудамж 12, Шинэ Үе сургууль, АйБи Оффис

“Ай Би” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар

Эх дэлхийгээ энх тайван байлгаж, одоо байгаагаас нь илүү сайхан ертөнцийг бий болгохын тулд хүнлэг чанараа танин мэдэж, энэ дэлхий ертөнцийг хамгаалах хамтын үүргээ ухамсарлан ойлгох чадвартай олон улсын сэтгэлгээтэй хүмүүс болгон хөгжүүлэхэд “Ай Би” хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

“Ай Би ” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар

ЭРЭЛХИЙЛЭГЧ Өөрсдийн сонирхсон зүйлсээ лавлан асуух, судлан шинжлэх чадвартай, аливаа зүйлд тэмүүлэлтэй, үргэлж суралцаж, хөгжих чадвартай иргэн болон төлөвшдөг.

МЭДЛЭГТЭЙ Тэд бүс нутагтаа болон олон улсад тулгамдсан асуудлын ойлголт, санаануудыг нээн олж чаддаг. Үүний үр дүнд тэрхүү ойлголт, санаа, асуудлынхаа талаар өргөн болоод тэнцвэртэй ойлголттой болж, гүн гүнзгий мэдлэг олж авч чаддаг. Олон талын мэдлэгтэй, түүнийгээ амьдралд хэрэглэх чадвартай иргэн болж төлөвшдөг.

ХЭРСҮҮ Нарийн төвөгтэй асуудлуудад дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй шийдвэр гаргахдаа шүүмжлэлт бүтээлч сэтгэлгээний чадварыг ашигладаг. Энэ нь тэднийг илүү хэрсүү ухаантай болгон хөгжүүлдэг.

ХАРИЛЦАГЧ Бусадтай илүү нээлттэй өөртөө итгэлтэй харилцаж, бусдыг ойлгож, анхааралтай сонсож тэдэнтэй хамтран ажиллах чадвартай иргэн болон төлөвшдөг.

ЗАРЧИМЧ Аливаа зүйлд зарчимч, шударга ханддаг, ёс зүйтэй, хууль дүрмийг чанд сахидаг, хүмүүсийн нэр төр ба эрхийг хүндэтгэж, өөрсдийн үйлдэл, тэдгээрийн үр дагавруудад хариуцлага хүлээж чаддаг иргэн болж төлөвшдөг.

НИЙТЭЧ Өөрсдийн соёл, бусдын үнэт зүйлс, уламжлалыг хүндэлж, бодитойгоор

үнэлэн дүгнэдэг, юмсыг олон талаас нь харах чадвартай, туршлагаасаа суралцаж өсөн дэвжихэд бэлэн байдаг иргэдийг бэлддэг.

ХАЛАМЖТАЙ Өөрсдийгөө бусдын оронд тавьж, бусдыг энэрч, хүндэтгэдэг, бусдын амьдрал болон хүрээлэн буй орчинд эерэг өөрчлөлт авч ирж чаддаг иргэн болон төлөвшдөг.

ШИЙДЭМГИЙ Аливаа тодорхойгүй зүйлд шийдэмгий хандаж, шинэ шинэлэг санааг судлахын тулд бие даан болон хамтран ажиллах чадвартай, сорилт бэрхшээл, өөрчлөлтийн өмнө бэлэн зогсож чаддаг, хөрвөх чадвар сайтай иргэн болон төлөвшдөг.

ТЭНЦВЭРТЭЙ Өөрсдийн болон бусдын сайн сайхан зүйлсийн төлөө оюун ухаан, бие бялдар, болон сэтгэл хөдлөл зэрэг амьдралынхаа янз бүрийн төлөвийг тэнцвэржүүлэхийн чухал ач холбогдлыг ойлгодог, бусад хүмүүс болон амьдарч буй ертөнцтэйгөө харилцан хамааралтайгаа хүлээн зөвшөөрдөг уян хатан иргэн болон төлөвшдөг.

ЭРГЭЦҮҮЛЭГЧ Аливаа зүйлсийн мөн чанарыг эргэцүүлэн бодож, юмсын сайн муу, үнэн зөвийг ялган таньж ухаалгаар шийдвэрлэж чаддаг.

АйБи хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанарын талаарх дэлгэрэнгүйг www.ibo.org/recognition сайтаас орж үзнэ үү.

Агуулга

“Ай Би” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар	3
Агуулга	4
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
СУДЛАХ ХЭЛ	5
Монгол хэл:	6
Англи хэл:	6
Орос хэл:	7
Төрөлх хэл:	7
ХЭЛ ЗААХ БОЛОН СУРАХ АРГА ЗҮЙ	7
Суралцах эх сурвалжууд:	8
ЖУРМЫГ ХЯНАН ӨӨРЧЛӨХ ЯВЦ	9
Ашигласан материалын жагсаалт	11

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Шинэ үе сургууль (цаашид “ШҮС” гэх) нь International Baccalaureate буюу Олон улсын бакалавратын байгууллагаас албан ёсоор тунхагласан доорх ерөнхий зүй зарчмуудыг хүлээн зөвшөөрч дэмждэг. Үүнд:

“Төрөл бүрийн хэл соёл заншилтай сурагчдад олон хэл эзэмшүүлэх нь тэдний өөр хоорондын харилцан ойлголцолд түлхэц өгч, тэднийг олон улсын цар хүрээтэй сэтгэх чадвартай болгох суурь тулгуур мөн гэсэн үзэл баримтлалыг Олон улсын бакалавратын байгууллага тууштай баримтлан дэмжихийн сацуу, төрөл бүрийн хэл соёлын өв уламжлалыг тээгч сурагчдыг олон улсын АйБи хөтөлбөрийн дагуу суралцуулах боломжийг нэмэгдүүлэх эрхэм зорилготой. Энэхүү эрхэм зорилго нь Олон улсын бакалавратын байгууллагын үйл

ажиллагаагаар дамжин илэрхийлэгдэхүйц байлгахын тулд олон хэлний харилцааг зохицуулах цар хүрээг тогтоох үүднээс АйБи хөтөлбөрийн хэлний бодлогыг боловсруулж баталсан болно”.

“АйБи хөтөлбөрүүдийн тухайд гэвэл, хэл бол бодитойгоор эрэгцүүлэн дүгнэж сэтгэх ур чадварыг зүгшрүүлж хэвшүүлэхэд гол үүрэгтэйгээс гадна, олон соёл, ёс заншилын зааг ялгааг танин мэдэх, олон улсын цар хэмжээнд бодож сэтгэх болон даяаршин буй нөхцөлд зохицон иргэнших чадвар суулгах зайлшгүй чухал хэрэглүүр хэмээн үздэг. /Language and learning in IB programmes эх сурвалжаас/

Шинэ үе сургууль хэл сурах хөтөлбөртөө Олон улсын бакалавратын байгууллагын доорхи стандартуудыг нэвтрүүлэхийг зорьж буй болно. Үүнд:

- Сургууль нь хэлний сургалт, тухайлбал төрөлх хэл, цаашид сурагчдынхаа суралцах өөр улс орны хэл болон бусад хэлний сургалтыг чухалчлан үзнэ (IB Standard A, Practice 7).
- Хамтран төлөвлөж, харилцан ярилцаж хэвшиснээр, бүх хичээл заадаг багш нар сурагч нэг бүрийнхээ хэл яриаг хөгжүүлэх үүрэг хүлээнэ (IB Standard C1, Practice 8).
- Хэл заах, сурах үйл явцыг сурагчдын хэлний мэдлэгийн янз бүрийн шаардлага хэрэгцээтэй нь, үүний дотор сурагчдын төрөлх хэлнээс өөр бусад хэл сурах шаардлага хэрэгцээтэй нь уялдуулна (IB Standard C3, Practice 7).
- Бүх багш нар сурагчдын хэл яриаг хөгжүүлэх үүргээ биелүүлж буй эсэх нь хэл заах, сурах үйл явцаар харагдана (IB Standard C3, Practice 8).

СУДЛАХ ХЭЛ

Анги	Нас	Монгол хэл /7 хоногт/	Англи хэл /7 хоногт/	Орос хэл /7 хоногт/
------	-----	-----------------------	----------------------	---------------------

I	6	7 цаг	4 цаг	-
II-V	6-11	6 цаг	5 цаг	-
VI-IX	12-14	VI-р ангид 7 цаг VII-IX-р ангид 6 цаг	6 цаг	VII-VIII-р ангид 2 цаг IX-р ангид 3 цаг
X	15	4 цаг	6 цаг + 1 цаг	-
XI	16	4 цаг	6 цаг + 2 цаг	-
XII	17	4 цаг	6 цаг + 4 цаг	-

Монгол хэл:

Монгол хэл нь сургалтын үндсэн бөгөөд хоорондын бүхий л харилцааны хэл мөн. Хэдийгээр сурагчид ирээдүйд гадаадын их дээд сургуульд суралцах төлөвлөгөөтэй байлаа ч гэсэн, бид түүнийг үл харгалзан төрөлх хэлээ төгөлдөр эзэмшихийг маш их дэмждэг. Хуучин монгол бичиг бол 6-9 дүгээр ангийн заавал судлах хичээл. Өөрийн язгуур хэл соёлоо мэдэх нь хэн бүхэнд зайлшгүй чухал.

Өөр улс орноос шилжин ирэх сурагчдыг тэдгээрийн монгол хэлний мэдлэгийг бусад хичээл ойлгохуйц түвшинд хүргэх үүднээс бага ангийн сурагчдад ангийн багшийн, дунд ба ахлах ангийн сурагчдад монгол хэлний багшийн хичээлээс гадуур монгол хэлний нэмэлт давтлагад хамруулна (Манай элсэлтийн журмыг www.shineue.edu.mn/policy хуудаснаас үзнэ үү). Монгол хэлний багш нар хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд өөрсдийн давтлагын цаг болон хичээлийн төлөвлөгөөг гарган сургалтын менежерээр батлуулах ёстой.

Бүх монгол сурагчид IB дипломын хөтөлбөрт хамрагдахдаа Монгол уран зохиол хичээлийг сонгон судалсан байхыг зөвлөж байна.

Англи хэл:

Манай сургууль англи хэлийг сурагчиддаа нэгдүгээр ангиас эхлэн ахлах ангиа төгсгөл нь заадаг хоёрдох хэл юм. Англи хэл нь англи хэл болон 9-10 дугаар ангид ордог IB дипломын хөтөлбөрт бэлдэх хичээлүүд болох биологи, физик, математик зэргийг заах үндсэн хэл бөгөөд IB дипломын хөтөлбөрийн А-хэлний монгол уран зохиол хичээлээс бусад бүх хичээлийг заах үндсэн хэл юм.

Манай хичээлээс гадуурх зарим нэг клуб, дугуйлан, тухайлбал байгаль шинжлэлийн клуб, мэтгэлцээний клуб, уншлагын дугуйлангийн харилцааны гол хэл нь англи хэл. Манай сургууль Олон улсын бакавлавратын байгууллагатай англи хэлээр харилцдагаас гадна, сургуулийнхаа дотоод дүрэм журмыг англи хэл дээр боловсруулдаг.

Англи хэлний бүх багш нар хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд хичээлээс гадуур ажиллах давтлагын цагийн хуваарийг сургалтын менежертэй ярилцан зохицуулна. Одоо суралцаж буй сурагчдаас англи хэлээр бусдаас хоцрогдолтой байгаа сурагчдын тухайн үеийн мэдлэгийн түвшинг нь харгалзан тэднийг долоо хоногт хамгийн багадаа нэг удаа хичээлээс гадуурх англи хэлний нэмэлт сургалтад хамруулж хоцрогдлыг арилгадаг.

Ерөнхий боловсролын улсын сургуулиудаас манай сургууль руу шилжин ирж буй сурагчдын англи хэлний түвшинг англи хэл дээр судалдаг бусад хичээлийг ойлгохуйц хэмжээнд хүргэх үүднээс хичээлээс гадуурх англи хэлний нэмэлт сургалтад хамруулна. (Манай элсэлтийн журмыг www.shineue.edu.mn/policy хуудаснаас үзнэ үү). Хичээлээс гадуурх англи хэлний нэмэлт сургалт нь хамгийн багадаа хичээлийн 60 цагаас (хичээлийн 1 цаг 40 минут байна) бүрдэнэ. Англи хэлний багш нар өөрсдийн нэмэлт сургалтын хуваарь болон хичээлийн төлөвлөгөөг сургалтын менежерээр батлуулна.

Манай сургуульд дунд ангиасаа эхлэн суралцсан сурагчдаас бусад Шинэ Үе сургуулийн сурагчид АйБи дипломын хөтөлбөрт элсэх бол хоёрдогч хэлийг англи хэлний ахисан түвшинд (English B HL) сонгохыг зөвлөж байна. Харин дунд ангиасаа англи хэл заалгаж эхэлсэн сурагчдын хувьд АйБи дипломын хөтөлбөрт элсэх бол хоёрдогч хэлийг англи хэлний энгийн түвшин; (English B SL) сонгохыг зөвлөж байна.

Орос хэл:

Боловсролын яамны шаардлагын хүрээнд 7-9 дүгээр ангийн сурагчдад анхан шатны орос хэлний хичээл заах журамтай. Энэхүү шаардлагыг биелүүлэх болон олон хэлний сургалтын үзэл санааг дэмжих үүднээс манай сургуульд орос хэлний хичээлийг унаган орос хэлтэй багш нар заадаг.

Төрөлх хэл:

Хэрэв IB Диплом хөтөлбөрийн сурагчийн төрөлх хэл нь монгол хэл ба англи хэлнээс өөр бусад хэл бол тухайн сурагчийн төрөлх хэлний сургалтыг дэмжих үүднээс сургууль нь IB байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн онлайн сургалтад бүртгүүлэх эсвэл гэрийн багш олох хэлбэрээр туслах болно (онлайн сургалт болон гэрийн багшийн зардал сургалтын төлбөрт багтахгүй болно).

ХЭЛ ЗААХ БОЛОН СУРАХ АРГА ЗҮЙ

ШҮС-д хэлийг бүх чадварыг зэрэг хөгжүүлэх аргаар заадаг. Унших, бичих, ярих, сонсох болон хэлний хэрэглээ гэсэн чадамжуудаар хүрэх үр дүнг хичээл бүрээр тодорхойлсон байдаг. Тус сургуулийн тэнхимийн эрхлэгч болон сургалтын менежерүүд эдгээр чадамжууд нь өнөө үеийн боловсролын шаардлага хэрэгцээг хангаж чадаж байна уу гэдэгт хяналт тавин, шаардлагатай үед шинэчлэн боловсруулна.

Бид сурагчдын хэлийг хөгжүүлэх нь манай нийт хамт олны үүрэг хэмээн ойлгодог. Иймээс ч, манай тэнхимүүд болон заах аргын нэгдлүүд долоо хоног тутам уулзаж энэхүү шаардлагыг хичээлийн бүтэн жилийн туршид хамтран хэлэлцэж боловсруулдаг гэсэн үг.

Ингэснээр, багш нар сургуулийн хэмжээнд зааж буй бүх хичээлүүдийн өөр хоорондын агуулгыг уялдуулан сайжруулах боломжтой болдог.

Манай сургуулийн гадаад хэлний тэнхим нь ерөнхий боловсролын хүрээнд тавигдаж буй шаардлагуудыг ханган биелүүлэхэд өнөө үед зайлшгүй хэрэгцээтэй байгаа гадаад хэлний ур чадварыг дээшлүүлэх тал дээр сурагчдад тулгарч буй бэрхшээлийг даван туулахад нь тэдэнд туслах үүднээс төрөл бүрийн арга зүйг боловсруулах, олон талын үйл ажиллагааг зохион байгуулах, хичээлээс гадуурх дугуйлангууд нээх зэргээр тасралтгүй ажиллаж байгаа болно.

Багш нар заах хичээлийнхээ хүрээнд хэл сурахад тус дөхөм үзүүлж болохуйц үйл ажиллагаа:

- Хэл идэвхийлэн сурах орчныг бүрдүүлж, долоо хоногт/улиралд тухайн заасан хичээлийн аль нэг бүлэг/сэдэвт холбогдох мэргэжлийн гол гол үг хэллэг, нэр томъёог шүүн түүвэрлээд, утга агуулгыг нь тайлбарлах, жагсаан бичүүлэх/самбарт тавих
- Нэг сэдэв агуулгын хүрээнд өмнөх мэдлэг ойлголтод суурилсан төрөл бүрийн үйл ажиллагаа явуулснаар аль нэг сэдвийн талаар өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэх
- Үгсийн санг бүтээлчээр хэрэглэж сургахад голлон анхаарч, бичих дадлага эзэмшүүлэх дасгалыг долоо хоног/сар тутам тогтмол хийлгэх, бичгийн чадварыг нэмэгдүүлэх боломж олгох үүднээс тухайн зохион бичлэгүүдийг анги бүлгээрээ хамтран хянан засварлах
- Уншиж ойлгох чадварыг нэмэгдүүлэх үүднээс график, хүснэгт, зурагт үзүүлэн бэлдэх үйл ажиллагаа явуулах, ном сэтгүүл уншиж ашиглах дадлага суулгахад голлон анхаарч, уншлагын дасгал сургалтыг долоо хоног/сар тутам зохиох

Суралцах эх сурвалжууд:

Сурагчид сургалтын олон сэдэв төрлийн талаар олон хэл дээр унших боломж олгох үүднээс хэлний бүх багш нар тэд нарыг тийм эх сурвалжаар хангах буюу сургалтын чанарын шаардлага хангах ном зохиолыг тэдэнд танилцуулж зөвлөх үүрэгтэй. Сурагчид манай сургуулийн номын санд байгаа төрөл бүрийн толь бичиг, сонин сэтгүүлийг ашиглах боломжтойгоос гадна тэдгээрийг тус номын сангаар дамжуулан захиалж болно. Сурагчдад хэл сурах нэмэлт боломж олох үүднээс хичээлийн бусад цагаар тус сургуулийн компьютерийн лабораторид сууж ажиллан хэл сурах төрөл бүрийн программыг нээж ашиглахыг зөвшөөрдөг.

Англи хэлний багш нарын хувьд **Twinkl** сайтаас багш нар хэрэгцээтэй материалаа авч баяжуулан хэрэглэдэг.

ЖУРМЫГ ХЯНАН ӨӨРЧЛӨХ ЯВЦ

Энэхүү журмыг хамгийн сүүлд хянан засварлаж өөрчилсөн өдрөөс хойших хоёр жил тутам дахин хянан өөрчилж байх болно. Хамгийн сүүлд энэхүү журмыг өөрчилсөн он, сар, өдөр уг журмын хуудас бүрийн баруун доод буланд тэмдэглээстэй байх ёстой. Журамд оруулах аливаа өөрчлөлтийн талаарх санал санаачилгыг нийт багш нарын 70 хувиас доошгүй ирцтэй багш нарын хурлаар хэлэлцэн батлах ёстой. Багш нар тийнхүү журамд оруулахаар санал болгосон өөрчлөлтийг санал хураалтаар батална.

Тийнхүү баталсан засвар өөрчлөлтүүдийг сургуулийн захирал, сургалтын менежерүүд, хөтөлбөрийн зохицуулагч болон тэнхимүүдийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй сургуулийн захиргаа дахин хянан үзэж, бусад журам болон дотоодын хууль тогтоомжид үл харшлахаар байвал батална.

Журамд хамгийн сүүлд оруулсан аливаа засвар өөрчлөлт нь сургуулийн захиргаанаас өөрөөр шийдвэрлээгүй бол дараагийн хичээлийн жилээс эхлэн хүчин төгөлдөр болно.

Ашигласан материалын жагсаалт

1. International Baccalaureate Organization (2017). DP Grade Descriptors. Retrieved April 8, 2021.
2. International Baccalaureate Organization (2015). DP: From principles into practice. Retrieved April 8, 2021.
3. International Baccalaureate Organization (2018). Diploma Programme Assessment Procedures. Retrieved April 8, 2021.
4. International Baccalaureate Organization (2010). Guidelines for developing a school assessment policy in the Diploma Programme. Retrieved April 8, 2021.
5. SUS IBDP Handbook 2021-2023. Retrieved May 5, 2021.

ЮНЕСКО-12, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар, Монгол улс

АйБи Дипломын Хөтөлбөр
2021-2023 Хэлний журам